

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2011 оны 04 дүгээр сарын
18-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 03

*Зүүнбаян, Цагаан-Элсний 97БХГ-т
талбайн газрын тосны нөөцийн тайлан*

“Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын Шенлигийн Газрын тосны удирдах товчооны Геологийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн боловсруулсан Дорноговь аймгийн нутаг дахь Зүүнбаян, Цагаан-Элсний 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээг (97БХГ) талбайн газрын тосны нөөцийн тайлан болон түүнд шинжээч хийсэн А.Эрдэнэлүрэв (ахлагч), Ц.Амраа, П.Санж, А.Пүрэв, Д.Алтанхуяг (нарийн бичиг) нарын шүүмж, дүгнэлтийг ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар **ХЭЛЭЛЦСЭН** нь:

1. Зүүнбаян, Цагаан-Элсний бүтээгдэхүүн хуваах гэрээг (97БХГ) талбайн газрын тосны нөөцийн тайлангийн зохиогч нь Юу Гуанхуа (Yu Guanghua), Лу Гуанжун (Lu Guangjun), Ген Бин (Gen Bin) нар байна.
2. Зүүнбаянгийн орд нь 1948 онд нээгдэж, 1950 онд олборлож эхэлсэн боловч 1969 онд олборлолтыг хаасан байна. Энд нийт 265 цооног өрөмдсөнөөс 1970 оноос өмнөх хугацаанд 263 цооногоос 561.9 мян. тонн (4017585 баррель) тос олборложээ. 1994 оноос зарим нэг цооногуудыг сэргээх, турших ажил хийгдэж байжээ. Цагаан элс XIII, Зүүнбаян XIV талбайд АНУ-ын “Нескор Энержи” компани газрын тосны хайгуулын ажлыг Хамтарсан хайгуулын хэлэлцээрийн дагуу 1993 онд эхэлж, улмаар дээрх талбайнуудын зарим хэсэгт 1997 оны 1 дүгээр сарын 24-нд Бүтээгдэхүүн Хуваах Гэрээг (БХГ) Газрын тосны хэрэг эрхлэх газартай байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний 47 дугаар тогтоолоор батлуулсан байна. Энэхүү БХГ-ний эрх, үүргийг Австралийн “Рок Ойл” компани 1998 онд авч, 2003 оны 2 дугаар сарын 15-нд БНХАУ-ын Шенлигийн газрын тосны товчооны (SINOPEC) харьяа “Доншен Жингүн Петролеум Дивилопмент Групп Сток” компанид шилжүүлснээс хойш “Доншен газрын тос (Монгол)” ХХК хэрэгжүүлж байна. Гэрээг талбай нь Цагаан Элс XIII ба Зүүнбаян XIV блокуудыг хэсэгчлэн хамарч нийтдээ 5321 км² талбайтай.
3. Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ) талбайд 1991-2009 онуудад нийт 5144 тууш км-г 2 хэмжээст, 340 км² талбайд 25x25 м тороор 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийгдэж, хайгуул, үнэлгээний 82 цооногийг нийт 124611.5 т.м өрөмдсөн байна.
4. 97БХГ талбай нь структурын хувьд Дорноговийн сав газрын төв хэсэгт байрлана. Тус блокын талбайд Зүүнбаян ба Үнэгтийн гэсэн хоёр дэд сав газар ялгасан байна. Зүүнбаянгийн дэд сав газрын блок тус бүрийн газрын тосны шинж чанар өөр хоорондоо ялгаатай байна. Газрын тос нь дунджаар 0.874-0.885 г/см³ хувийн жинтэй бөгөөд парафины агууламж 23.9-42.7% байна.
5. Доод Зүүнбаян, Цагаанцав формацийн чулуулаг дахь зарим цооногуудаас (TE142, TE14-25, TE27-1, TE1-1, TE1-6, ZBN2, WTE2) чөмгөн дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэжээ. Газрын тос, түүнийг агуулагч чулуулгийн бүтэц-структур,

шинж чанар ба тэдгээрийн бүрэлдэхүүний хувьд газрын тосны шинжилгээг Доншен группын лабораторийн судалгааны төвд, чөмгөн дээжийг Шенлигийн орд газрын геологийн хүрээлэнгийн газрын тос, геологийн лабораторт шинжлүүлсэн байна.

6. Тайлангийн зохиогч нар Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ)-ний ордод 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар газрын тосны геологийн нөөцийг тос агуулагч 18.3 км² талбайн 7 блокт баталгаат зэрэглэлээр 26.05 сая тонн буюу 186.3 сая баррель, 49.36 км² талбайн 3 блокт боломжит зэрэглэлээр 25.59 сая тонн буюу 182.9 сая баррель, нийт 67.66 км² талбайн 10 блокт 51.64 сая тонн буюу 369.2 сая баррель, үүнээс ашиглах нөөц нь баталгаат зэрэглэлээр 2.08 сая тн буюу 14.86 сая баррель, боломжит зэрэглэлээр 1.41 сая тн буюу 10.09 сая баррель, нийт 3.49 сая тн буюу 24.95 сая баррель гэж тус тус тооцоолжээ.

7. Харин шинжээч нар дээрхи геологийн нөөцөөс TE-1, TE-14, TE-27, ZB-SWZB гэсэн 4 блокод баталгаат, WTE-1, EZB-1, EZB-4 гэсэн 3 блокод магадтай, WTE-2 блокод боломжит зэрэглэлээр, EZB хагарлын бүсийн доод Зүүнбаян (Шинэхухудаг) болон Цагаанцав формацид агуулагдах газрын тосыг баялгаар үнэлж Монгол Улсын эрдсийн нөөцийн санд бүртгэх дүгнэлт гаргасан байна.

8. “Доншен газрын тос (Монгол)” ХХК нь Зүүнбаян, Цагаан элсний ордоос 2009 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 760681 тн буюу 5438869.2 баррель газрын тос олборлосон гэж тайланд тусгажээ.

9. Газрын тосыг 60\$/bbl, 80 \$/bbl ба 100 \$/bbl гэсэн гурван үнээр эдийн засгийн үнэлгээг хийхэд үнэлгээний хугацаанд санхүүгийн цэвэр орлого нь 86.78 сая ам.доллар, 189.86 сая ам.доллар ба 287.33 сая ам.доллар тус тус байна. Газрын тосны үнэ 60\$/bbl ба 80\$/bbl байхад өртгийн сан нь нехөгдөх боломжгүй, харин 100\$/bbl байхад өртгийн сан нь 2023 онд бүрэн нехөгдөх боломжтой гэж тооцоолжээ.

Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналын үндсэн дээр хуралдааныг даргалагчийн зүгээс хэлэлцэж буй асуудлаар ЭБМЗ-өөс гаргах дүгнэлтийн төслийн шийдвэрийн хэсгийг танилцуулж, олонхийн саналаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах төслийн дагуу шийдвэр гаргахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ)-ний ордод 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар газрын тосны геологийн нөөцийг тос агуулагч 18.3 км² талбайн TE-14, TE-1, TE-27, ZB ба SWZB, EZB-1, EZB-4, WTE-1 гэсэн 7 блокт баталгаат зэрэглэлээр 26055.94 мян. тн буюу 186300.0 мян. баррелиар, 49.36 км² талбайн WTE-2, EZB хагарлын бүсийн 3 блокт боломжит зэрэглэлээр 25580.42 мян. тн буюу 182900.0 мян. баррелиар, үүнд:
 - 1.1. Ашиглалтын нөөцийг баталгаат зэрэглэлээр 2079.12 мян. тн буюу 14865.70 мян. баррелиар,
 - 1.2. Олборлосон тосыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар баталгаат нөөцөөс 831.23 мян. тн буюу 5943.29 мян. баррелиар, боломжит нөөцөөс 0.04 мян. тн буюу 0.28 мян. баррелиар,
 - 1.3. Үлдэгдэл ашиглалтын нөөцийг баталгаат зэрэглэлээр 1247.89 мян. тн буюу 8922.41 мян. баррелиар тус тус Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэх (хавсралт хүснэгт);

2. Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ)-ний ордын газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг жил бүр зохих журмын дагуу хийж, АМГ-ын Геологийн мэдээллийн санд бүртгүүлж байхыг Газрын тосны газар болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-д даалгах,
3. “Монгол Улсын 97БХГ талбайн газрын тосны геологийн нөөцийн тайлан” нь Газрын тосны газрын даргын 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар тушаалаар батлагдсан “Газрын тосны нөөцийн тооцооны тайлангийн агуулга, түүнд тавигдах шаардлага”-ыг хангахгүй байх тул холбогдох засвар хийлгэж, шинжээч нарт ирүүлэхээр бүрэн эхээр нь буцаах;
3. Газрын тосны баталгаат нөөцөд тулгуурлан түүнийг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзэх,
4. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-д даалгах нь:
 - 4.1. Цаашид ашиглалтын буюу гүйцээх хайгуулын ажил хийж, үйлдвэрлэлийн баталгаат зэргийн нөөцийг өсгөх,
 - 4.2. Нөөцийн үр дүнгийн тайланг зохих журмын дагуу дахин боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд шинжээчид болон ЭБМЗ-ийн холбогдох гишүүдээр хянуулан, Газрын тосны газарт болон Ашигт малтмалын газрын Геологийн мэдээллийн санд тус тус хүлээлгэн өгөх,
 - 4.3. Энэхүү дүгнэлтийн 4.2 дахь заалтыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд зохих арга хэмжээг авахыг анхааруулах;
5. Зүүнбаян, Цагаан-Элсний (97БХГ) ордод тогтоосон газрын тосны хайгуулын ажил, нөөцийн тооцооны үнэн бодит байдлыг “Доншен газрын тос (Монгол)” ХХК болон тайлангийн зохиогч, Газрын тосны газрын Техникийн зөвлөл, шинжээч нар тус тусын дүгнэлтийн хүрээнд хариуцах;
6. Монгол улсын газрын тосны нөөцийн ангилалын зааврыг боловсруулж, ЭБМЗ, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхийг Газрын тосны газар, ЭБЭХЯ-ны Түлшний бодлогын газарт даалгах.


ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ЭБЭХЯ-НЫ
ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ТОДБИЛЭГ



ЭБМЗ-ийн 2011 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн
03 дугаар дүгнэлтийн хавсралт

Зүүнбаян, Цагаан-Элсний ордын (97БХГ-т талбай) газрын тосны нөөцийн тооцоо
2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

№	Блокийн дугаар	Агуулагч давхарга	Тос агуулсан талбайн хэмжээ, кв.км	Баталгаат нөөц		Ашиглалтын баталгаат нөөц		Боломжит нөөц		Олборлолт, 2010.12.31-ний байдлаар		Ашиглалтын баталгаат нөөцийн үлдэгдэл		Боломжит нөөцийн үлдэгдэл	
				мян.тн	мян.баррель	мян.тн	мян.баррель	мян.тн	мян.баррель	мян.тн	мян.баррель	мян.тн	мян.баррель	мян.тн	мян.баррель
1	TE -14	Цагаанцав	3.41	7,854.55	56,160.00	471.27	3,369.60			123.44	882.60	347.83	2,487.00		
2	TE -1	Шинэхудаг	3.73	3,509.09	25,090.00	315.82	2,258.10			69.79	498.97	246.03	1,759.13		
3	TE -27	Шинэхудаг	2.2	1,937.06	13,850.00	174.34	1,246.50			71.50	511.25	102.83	735.25		
4	ZB ба SWZB	Цагаанцав	2.96	3,751.05	26,820.00	637.68	4,559.40			552.95	3,953.61	84.73	605.79		
5	EZB -1	Цагаанцав	1.68	2,528.67	18,080.00	151.72	1,084.80			9.44	67.47	142.28	1,017.33		
6	EZB -4	Цагаанцав	0.72	451.75	3,230.00	27.10	193.80			0.84	6.02	26.26	187.78		
7	WTE -1	Цагаанцав	3.6	6,023.78	43,070.00	301.19	2,153.50			3.27	23.37	297.92	2,130.13		
	нийт дүн		18.3	26,055.94	186,300.00	2,079.12	14,865.70			831.23	5,943.29	1,247.89	8,922.41		
8	WTE -2	Цагаанцав	2.27					5,226.57	37,370.0	0.03	0.21			5,226.54	37,369.79
9	EZB хагарлын бүс	Цагаанцав	32.46					13,186.01	94,280.0	-	-			13,186.01	94,280.00
10		Шинэхудаг	14.63					7,167.83	51,250.0	0.01	0.07			7,167.82	51,249.93
	нийт дүн		49.36					25,580.42	182,900.0	0.04	0.28			25,580.38	182,899.72

97БХГ-т талбайн TE-14, TE-1, TE-27, ZB & SWZB, EZB-1, EZB-4, WTE-1 блокуудад тооцсон газрын тосны баталгаат нөөцийн хэмжээ 26055.94 мян.тн буюу 186300 мян.баррель, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийн хэмжээ 2079.12 мян.тн буюу 14865.7 мян.баррель; WTE-2 блок болон EZB хагарлын бүсийн газрын тосны боломжит нөөцийн хэмжээ 25580.42 мян.тн буюу 182900 мян.баррель бөгөөд 2010.12.31-нийг хүртэл олборлосон тосны хэмжээг хассанаар ашиглалтын баталгаат нөөцийн үлдэгдэл 1247.89 мян.тн буюу 8922.41 мян.баррель болно.